



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/453

Булган сум

Гэрээ байгуулж, хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадмын бэлтгэл ажлын хүрээнд 8 ханатай гэр, 6 ханатай гэрийн засвар дотор тохижуулалт, тээврийн зардлыг хавсралтаар баталж, “Аз баатар” ХХК-тай гэрээ байгуулан ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга (Х.Энхбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Дээрх зардалд тусгагдсан 5,000,000 (таван сая) төгрөгийг, орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

06 дугаар сарын 20-ны өдрийн А/ИС дугаар захирамжийн хавсралт



8 ханатай гэр

Д/Д	Зардлын зориулалт	Тоо хэмжээ	Үнэ	Нийт дүн
1	2	3	4	5
1	Гадна улаан халзан цагаан бүрээс	1 ширхэг	1,100,000	1,100,000
2	Дотор цагаан бүрээс	1 ширхэг	200,000	200,000
3	Хивс		450,000	450,000
4	Хулдаас		500,000	500,000
5	Зуух	1 ширхэг	250,000	250,000
6	Яндан	1 ширхэг	60,000	60,000
7	Өрх	1 ширхэг	130,000	130,000
8	Нийт дүн			2,690,000

6 ханатай гэр

Д/Д	Зардлын зориулалт	Тоо хэмжээ	Үнэ	Нийт дүн
1	Гадна улаан халзан цагаан бүрээс	1 ширхэг	650,000	650,000
2	Дотор цагаан бүрээс	1 ширхэг	100,000	100,000
3	Зуух	1 ширхэг	250,000	250,000
4	Яндан	1 ширхэг	50,000	50,000
5	Өрх	1 ширхэг	70,000	70,000
6	Гар нүүрний угаалтуур	2 ширхэг	120,000	240,000
7	Шкап	1 ширхэг	405,000	405,000
8	Нийт дүн			1,360,000

Тээврийн зардал

Д/Д	Зардлын зориулалт	Тоо хэмжээ	Үнэ	Нийт дүн
1	Шатахуун	156 литр	3 480	545,000
8	Нийт дүн			545,000